



## САВНЫ ХҮЗҮҮНИЙ УЛАЙЛТ ЯАГААД БИЙ БОЛДОГ ВЭ?

Савны хэвцвний улайлт буюу умайн хэвцвний сувгийн үрэвсэл нь элбэг тохиолддог эмэгтэйчүүдийн үрэвсэлт овчний нэг юм. Ихэвчлэн торолт, үр хондолтийн улмаас умайн хэвцвнд үүссэн урагдал, гэмтэл, эмчлүүлээгүй буюу дутуу эмчлэгдсэн бэлэг эрхтний (үтрээ, умай, умайн гуурсан хоолой, ондговчийн) үрэвсэлт овчнүүд нь умайн хэвцвний суваг үрэвсэх гол шалтгаан болно.

Мөн дээрх үрэвслүүдийн багагви хэсэг нь БЗДХ –той холбоотой байдаг байна.

Умайн хэвцвний сувгийн үрэвсэлтэй үед тэр бүр зовиур шаналгаа үүсэхгүй, овчний эхэн үед бэлэг эрхтнээс ялгарах цагаан юмны хэмжээ ихсэх, онго нь оорчлогдох, хэвлийн доод хэсэг, ууц нуруугаар овдох шинжүүд гарч болох боловч ихэнхи эмэгтэйчүүд анзаарахгүй онгороодогоос овчин архагшин хүндэрдэг.

Түүнчлэн энэ овчин нь умайн хэвцвний омон буюу хорт хавдар үүсгэдэг суурь овчний тоонд ордог учраас эмэгтэй хүн бүр доод тал нь 6 сар тутамд нэг удаа эмэгтэйчүүдийн эмчид үзүүлж занших нь аливаа овчин эмгэгийг эрт илрүүлэх, цаг алдахгүй эмчлүүлэхэд сайнаар нолоолдог байна.

## ОНДГОВЧНИЙ ҮРЭВСЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Ондговч нь эмэгтэйн биед эм бэлгийн эсийг боловсруулах болон биений юмны үйл

ажиллагааг зохицуулдаг бэлгийн даавар ялгаруулах гэсэн 2 үндсэн үүргийг гүйцэтгэдэг аарцгийн хондид байрладаг бэлэг эрхтэн юм. Эмэгтэйчүүдийн овчний дотор ондговчийн үрэвсэл нилээд элбэг тохиолддог бөгөөд дангаараа овчилохоос илүүтэй умайн гуурсан хоолойн үрэвсэлтэй хавсарсан байх нь элбэг.

Ихэнхидээ үтрээ болон умайд байгаа халдвар огсох байдлаар тархсанаас үүсдэг. Оороор хэлбэл торолт, үр хондолтийн улмаас умайд үүссэн үрэвсэл болон янз бүрийн шалтгаантай үтрээний үрэвсэлүүдийг эмчлүүлэхгүй архагшуулснаас халдвар үтрээнээс умайн хондий рvv, умайн хондийгоос умайн гуурсан хоолой рvv, умайн гуурсан хоолойноос ондговч рvv дамжин тархах байдлаар овчлүүлдэг.

Харин цоон тохиолдолд уруудах замаар оороор хэлбэл мухар олгой, шулуун гэдэс тvнний дээд хэсэг, хошного зэрэг эрхтнүүдийн үрэвсэл тархаж ондговч болон умайн гуурсан хоолойг үрэвсүүлж овчлүүлдэг байна.

- Хэрвээ танд доорхи асуудлуудын аль нэг нь байгаа бол таны ондговч үрэвсэж овчлох магадлалтай тул заавал эмчид хандан эрvvл байгаа эсэхээ тодруулаарай.
- Урьд олно, хэзээ нэг цагт эмч таныг үзээд Таны ондговч үрэвсэлтэй байна, эмчлүүлээрэй гэсэн боловч та эмчлүүлэхгүй орхисон.
- Үе үе хэвлийн доод хэсэг, бүсэлхий, цавь орчмоор хатгуулж овддог
- Биений юмны мочлог алдагддаг
- Хэвлийн доод хэсгээр овдохийн хамт халуурч байсан
- Бэлэг эрхтнээс цагаан юм их гардаг эсвэл цагаан юмны онго, үнэр хэвийн биш санагддаг
- Үр хондvvлж байсан эсвэл торолт хvндрэлтэй явагдсан
- Умайн гаднах жирэмслэлт болж байсан.
- Умайн хондийдоо ерондогтэй
- Хамгаалалтгүй, найдвартай б  
иш бэлгийн харьцаанд ордог
- Хэвлийн хондийн идээт овчний улмаас хагалгаанд орж байсан

Овчний илрэл нь хурц тод байхын зэрэгцээ бүдэг, балархай ч байж болдог. Халдвар хир их талбайг хамарч овчлүүлсэн болон үүсгэсэн нянгийн хоруу чанар, тухайн хvний биеийн эсэргvvцэл зэргээс хамааран хэвлийн доод тал, бүсэлхийгээр овдох, халуурах, биений юмны вйл ажиллагаа хямрах зэрэг шинжvvд тод, бүдэг, хvчтэй, сул байдлаар илэрнэ. Хэрвээ ондговч болон умайн гуурсан хоолой идээлж үрэвсвэл энэ нь умайн гаднах жирэмслэлт болох, гуурсан хоолой битvvрэх, үргvйдэх зэрэг хvндрэлvvдийн гол шалтгаан болдог.

Харин мэргэжлийн эмчид цаг алдалгвй хандан оношлогоо, эмчилгээг хийлгэвэл бvрэн тогс эмчлэгддэг давуу талтай.

## САРЫН ТЭМДЭГ ХУГАЦААНДАА ИРЭХГҮЙ ЗАРИМ САРД ИРЭЭД, ЗАРИМДАА ИРДЭГГҮЙ ХЭЛБЭЛЗЭЭД БАЙДАГ НЬ ЯМАР УЧИРТАЙ ЮМ БЭ?

Юуны омо биений юмны мочлогоо зов тодорхойлох хэрэгтэй. Биений юм анх ирсэн одроос дараагийн ирэх одор хvртэлх хугацааг нэг мочлог гэж vзнэ. Хоорондоо хэд хоногийн зайтай ирж байгаагаар нь биений юмны вйл ажиллагаанд ямар нэг оорчлолт байгаа эсэхийг тодруулж болдог. Тиймээс эмэгтэй хvн бvр сарын тэмдгийн хуанли хотолж хэвших нь чухал юм. Энэ нь тийм ч тvвэгтэй биш богоод та тухайн оны календарь аваад тvvн дээрээ биений юм ирсэн одрvдээ дугуйлаад тэмдэглэхэд л хангалттай. Маш олон эмэгтэйчvд биений юмыг сард нэг удаа ирэх ёстой гэж ойлгодог буруу итгэл vнэмшилтэй байдаг.

Биений юмны мочлог 20-35 хvртэл хоногтой байж болох богоод ихэнхи эмэгтэйнх дунджаар 28 хоногийн мочлогтэй байдаг. Гэхдээ хvнд бvрд адилгвй. Доод тал нь 4-6 удаагийн биений юм vзэгдсэн хугацааг тасралтгвй тэмдэглээд хоорондоо хэд хоногийн зайтай байгаагаар нь таны биений юм хэд хоногийн мочлогтэй вэ гэдгийг тооцож болно. Биений юмны ирэх ёстой хугацаа 7 хоногийн дотор хойшоо, урагшаа хэлбэлзэж ирж болох богоод vннийг тогмол, хэвийн мочлогтэй гэж vзнэ.

Харин 20 хоногоос дотогш эсвэл 35 хоногоос дээш мочлогтэй эсвэл нэг удаа ирэхдээ 7 хоногоос дээш хугацаагаар vргэлжилдэг, овдолттэй ирдэг бол заавал мэргэжлийн эмчид хандаарай. Энэ нь умай, ондговч, тархины вйл ажиллагааны зохицуулга алдагдсантай холбоотой юм.

## ХЭВЛИЙГЭЭР ОВДООД БАЙНА ЭНЭ ЯМАР ОВЧИН БЭ?

Зовхон энэ зовиураар ямар нэг овчин байна гэж vзэх нь хангалттай биш. Хэвлийн яг аль хэсгээр овдож байна, овдолтийн хvч, vргэлжлэх хугацаа нь ямар байна, оор ямар нэмэлт зовиур илэрч байна зэрэг олон асуудлыг тодруулах шаардлагатай юм. Тийм болохоор оортоо таамаглаж онош тавихын омо орхийн эмчдээ эхлээд хандаарай. Танд vвссэн энэ зовиур дотрын, мэдрэлийн, мэс заслын, эмэгтэйчvддийн олон овчний вед илэрч болох тул мэргэжлийн эмчийн туслалцааг авах нь чухал.

Эх сурвалж Emch.mn